



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Соёл Урлагийн Их Сургууль,

Театрын урлагийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Жүжиглэх урлаг

Индекс: D021505

Шинжээчийн баг:

Ахлагч: С.Эрдэнэтуул

Гишүүд: А. Баярмэнд

Г.Батхуяг

Он сар өдөр: 2021.03.02

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	8
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	9
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	12
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	15
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	18
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	21
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	23
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	
I. Багш нарын нэрс	28
II. Оюутнуудын нэрс	28
III. Ажил олгогчдын нэрс.....	29
IV. Төгсөгчдийн нэрс	29
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	30
ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

- СУИС Соёл Урлагийн Их Сургууль
 - БШУЯ Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
 - БСШУЯ Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
 - БСШУСЯ Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
 - ДЧББ Дотоод Чанарын Баталгаажуулалтын Баг
 - ЕБС Ерөнхий Боловсролын Сургууль
 - ЖУ Жүжиглэх Урлаг
 - ЗГТ Засгийн Газрын Тэтгэлэг
 - КУДС Кино Урлагийн Дээд Сургууль
 - НЖУТ Найруулах, Жүжиглэх Урлагийн Тэнхим
 - ОНХ Олон Нийтийн Харилцаа
 - ОХ Оюутны Холбоо
 - ОХТ Оюутан Хөгжлийн Төв
 - ОХУ Оросын Холбооны Улс
 - РТМУС Радио Телевиз Медиа Урлагийн Сургууль
 - СА Сургалтын Алба
 - СБЗГ Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар
 - СС Соёлын Сургууль
 - СТА Соёлын Тэргүүний Ажилтан
 - СУИС Соёл Урлагийн Их Сургууль
 - СУСХ Соёл Урлаг Судлалын Хүрээлэн
 - ТББ Төрийн Бус Байгууллага
 - ТУДС Театрын Урлагийн Дээд Сургууль
 - ТУС Театрын Урлагийн Сургууль
 - ТШК Төгсөлтийн Шалгалтын Комисс
 - УБДС Улсын Багшийн Дээд Сургууль
 - УБГ Уран Бүтээлийн Газар
 - УДЭТ Улсын Драмын Эрдмийн Театр
 - УМС Удирдлагын Мэдээллийн Систем
- Орос**
- ГИТИС Государственный Институт Театральных Искусств
 - РГИСИ Российский Государственный Институт Сценических Искусств

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Соёл Урлагийн Их Сургууль, Театрын урлагийн сургууль School of Theatre Arts, Mongolian State University of Arts and Culture	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Жүжиглэх урлаг Acting Art	
Индекс	D021505	
Шинжээчид	<p>Шинжээчийн багийн ахлагч: С.Эрдэнэтуул- Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Академик чиглэл хариуцсан дэд захирал, доктор, профессор</p> <p>Шинжээчийн багийн гишүүд: А. Баярмэнд – Чөлөөт уран бүтээлч, Оросын Холбооны Улсын Санктпетербург хотын Урлаг судлалын институтын докторант Г.Батхуяг – Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл урлагийн газрын Урлаг, уран бүтээлийн хэлтсийн дарга</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Мядагмаа – БМИҮЗ-ийн Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021.03.01.	СУИС, Театрын урлагийн сургуулийн Жүжиглэх хөтөлбөрийн нотлох баримттай сургуульд очиж танилцсан.
	2021.03.02	Багш, оюутан, ажил олгогч, төгсөгчдийн төлөөлөлтэй цахим уулзалтуудыг хийсэн
	2021.03.02	Сургуулийн өөрийн үнэлгээний багт цахимаар шинжээчийн үнэлгээний тайланг урьдчилсан байдлаар танилцуулсан.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

1957 онд МУИС – ийн дэргэд А.Никитиний удирдсан үндэсний найруулагчийн анги, 1959 онд УБДС – ийн дэргэд кино драмын жүжигчний анги тус тус нээгдэж байсан байна. “Жүжиглэх урлаг” мэргэжлийн хөтөлбөрийг анх 2012 онд БМИҮЗ – өөр магадлан итгэмжлүүлсэн бөгөөд 2014 онд БСШУ – ны сайдын А/174 тоот тушаалын дагуу шинэчлэн баталсан. 2016 онд дахин шинэчилж, цогц чадамжийг 12 төрлийн мэдлэг, 15 чадвар, 11 хандлагаар тодорхойлжээ. Хөтөлбөрийн зорилго нь жүжигчин бэлтгэхэд зайлшгүй шаардагдах мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн хамарсан агуулга бүхий шатлан өргөжих, гүнзгийрэх чиглэлтэй, Монголын болон Өрнө, Дорнын тайз, дэлгэцийн урлагийн онол, түүхийг судалсан мэргэжлийн өндөр чадвартай, олон улсын жишигт нийцэхүйц хөрвөх чадвар бүхий бакалаврын боловсролтой жүжигчин бэлтгэхэд оршино.

“Жүжиглэх урлаг” хөтөлбөрөөр 1991 оноос 2016 он хүртэлх хугацаанд нийт 666 оюутан төгссөн нь сургуулийн нийт төгсөгчдийн 76.8%- ийг эзэлж байна. Төгсөгчид театр, киноны, хөгжимт театрын жүжигчин, драмын студи, дугуйланд багш, телевиз радиогийн нэвтрүүлэгч, хөтлөгч, кинонд дуу оруулагч, театр, соёл урлагийн байгуулагын продюссер, менежер ажлын байруудад ажиллаж боломжтой. Сүүлийн 5 жилд тус хөтөлбөрөөр 224 мэргэжилтэн бэлтгэгдсэн бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн дундаж 70.5 хувьтай байна. Олон улсын түвшинд АТЕС-ийн наадам, АРВ-ийн фестиваль зэрэг гадаадын наадмуудад оюутнуудыг тогтмол оролцуулахаас гадна сүүлийн жилүүдэд 5 багш гадаадад зочин профессороор уригдаж, мастер класс хийсэн байна. Тус хөтөлбөрийг анх 2012 онд магадлан итгэмжлүүлсэн бөгөөд энэ удаа 2 дахь удаагаа магадлан итгэмжлүүлэхээр хүсэлт гаргасан байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт, хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмаркинг судалгааны танилцуулга /PEST, STEP шинжилгээ/
- Гадаад, дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмаркинг
- Оюутнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны тайлан
- Төгсөгчдөөс авсан сэтгэл ханамжийн судалгааны тайлан
- Нийслэлийн хэмжээнд мэргэжлийн урлагийн байгууллагад ажиллаж буй мэргэжлийн боловсон хүчний 86 хувь нь СУИС-ийн төгсөгч, орон нутгийн урлагийн байгууллагад ажиллаж буй хүний нөөцийн 80 хувь нь СУИС-ийн төгсөгч байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын болон үндэсний түвшний ижил төрлийн хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийн, хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах ажлыг хийж байна.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн ажиллах боломжит ажлын байруудыг тодорхойлж, ажлын байранд шаардагдах ур чадварын үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлсон.
- Оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгааг авч, хэвшсэн байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчдын тавьж буй шаардлага, хэрэгцээг тодорхойлоход орон нутгийн байгууллагуудын оролцоо сул

Зөвлөмж:

- Орон нутгийн соёл, урлагийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулах, ажил олгогчдын судалгаанд тэдний төлөөллийг нэмэгдүүлэх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн мастер төлөвлөгөө
- Театрын урлагийн сургуулийн захирлын мөрийн хөтөлбөр
- “Жүжиглэх урлаг” мэргэжлийн хөтөлбөр
- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн шинэчлэл хийсэн хэлэлцүүлэг, хурлын протоколууд
- Хөтөлбөрийн хорооны хурлын шийдвэр
- Оюутнууд, төгсөгчид, ажил олгогчдоос авсан судалгааны тайлангууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго нь СУИС-ийн болон Театрын урлагийн сургуулийн зорилготой нийцсэн байдлаар тодорхойлогдсон.
- Хөтөлбөрийн зорилтод оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд тулгуурлан байнгын сайжруулалт хийх асуудлыг тусган, сайжруулалтыг тогтмол хийж, хэвшсэн байна.
- Оюутнуудаас хичээл бүрээр улирал тутам судалгаа авч, үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглаж, хэвшсэн байна.
- Тухайн салбартаа томоохон ажил олгогчид нь сургуулийн үйл ажиллагаанд цагаар хичээл заах, дадлага удирдах, дадлагын оюутнуудыг тодорхой бүтээлүүд дээр авч ажиллуулах зэргээр хамтын ажиллагаатай байдаг нь хөтөлбөрийн сайжруулалтад эерэгээр нөлөөлдөг.

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

- Оролцогч талуудтай хийсэн уулзалтаар төгсөгчдийн дижитал чадвар дутмаг байдаг талаар нийтлэг саналууд гарсан тул, шинээр байгуулагдсан студийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах, студи лабораторийг нэмж байгуулах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- “Жүжиглэх урлаг” мэргэжлийн хөтөлбөр
- Хөтөлбөрийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэрүүд
- Сургалтын төлөвлөгөө, сургалтын хуанли
- Батлагдсан хичээлийн хөтөлбөрүүд /түүврээр/
- Мэргэжлийн багшийн хичээлийн хавтас
- Цахим сургалтын платформ

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн баримт бичгийг БШУЯ-ны “Сургалтын баримт бичиг боловсруулахад баримтлах нийтлэг журам”, “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу боловсруулсан.
- CDIO аргачлалыг өөрийн онцлогт тохируулан нийцүүлж, хөтөлбөрөөр олгох мэдлэг, чадвар, хандлагыг цогц чадамж байдлаар тодорхойлсон.
- Хөтөлбөрийн матрицыг зураглаж, хичээл хоорондын уялдаа холбоог тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр олгох мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлохдоо мэдлэг, хандлагын хэсэгт зарим чадварууд орсон байгааг засах
- Энэхүү үр дүнд суурилсан хөтөлбөрийн боловсруулалтыг баталгаажуулж, сургалтын төлөвлөгөөтэй уялдуулах
- Хичээлийн хөтөлбөрт тухайн хичээлийн суралцахуйн зорилтот үр дүнгүүд хөтөлбөрт ямар хувь нэмэр оруулж байгааг тодруулах
- Хөтөлбөр боловсруулах нэгдсэн аргачлал байгаа учраас тэрхүү аргачлалын дагуу хичээлийн хөтөлбөрүүдээ сайжруулах ажлыг үргэлжлүүлэх

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн матриц дотор тухайн хичээлийн суралцахуйн зорилтот үр дүнгүүд цөөн газар зөрүүтэй байгааг засварлах
- Төгсөгчийн нийтлэг загварт сонгох хичээлүүдийг оруулсан байгааг дахин хянах

Шаардлага:

- Шинэ аргачлалаар боловсруулсан хөтөлбөрийг баталгаажуулах, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийн багц цагийн харьцааг сайжруулах
- Хөтөлбөрийн төгсөгчийн загварт орсон давхардсан агуулга, зөөлөн чадвар, хандлагын ялгааг тодруулан засварлах
- Хичээлийн хөтөлбөрт тухайн хичээлийн зорилтот үр дүнгүүд нь мэргэжлийн хөтөлбөрийн ямар үр дүнтэй уялдаж байгааг тодорхойлох

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн зорилтот үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын төлөвлөгөө
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан зураглал
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Сургалтын журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Мэргэжлийн ур чадвар олгох практик хичээлүүд ихэнх хувийг эзэлдэг
- Олон жилийн заах арга зүйн туршлагатай, өөрийн гэсэн дэг сургуулийг бий болгосон
- Хичээлүүд хоорондоо залгамж холбоо бүхий, тодорхой мэргэжлийн чадваруудыг суулгахад чиглэгдсэн
- 2012 оноос хойш 2 удаагийн шинэчлэлт хийж, тасралтгүй хөгжиж байна

Анхаарах асуудал:

- Оюутнуудын сурлагын голч дүнгийн үзүүлэлт тааруу байгаад ерөнхий суурийн хичээлүүдийн нөлөөлөл их байна.

Зөвлөмж:

- Ерөнхий суурь хичээлийг мэргэжлийн онцлогт тохируулан сонирхолтой, үр дүнтэй болгох
- Гадаадын сургуулиудын хөтөлбөртэй нарийвчлан танилцах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн хөтөлбөрүүд
- Багшийн хичээлийн хавтас
- Үнэлгээний журам
- Сургалтын журам
- Цахим сургалтын платформ

- Цахим контентүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн онцлогоос шалтгаалан интерактив хичээлүүд давамгайлдаг.
- Зарим мэргэжлийн чадвар олгох хичээлүүд ганцаарчилсан сургалтын арга зүйд тулгуурлан өгөгддөг.
- Өөрийн цахим сургалтын платформыг хэрэглээнд нэвтрүүлсэн.
- Хичээлд харилцан ярилцах, үзүүлэх, дадлага хийх, багаар ажиллах, тоглоомын аргуудыг хосолсон байдлаар түлхүү ашигладаг.

Анхаарах асуудал:

- Цахим сургалтын платформ хэрэглээнд орсон боловч, багш нарын бэлтгэсэн видео контент хангалтгүй байна.
- Багш бүр өөр өөрийн боломжид тулгуурлан онлайн аар хуваарьт цагтаа хичээлээ орж байгаа нь хөндлөнгийн хяналт тавихад төвөгтэй байна.

Зөвлөмж:

- Олон жилийн дадлага, туршлагатай багш нарын заах арга зүй, оюутнуудын бие биенээсээ суралцах боломжийг нэмэгдүүлэхийн тулд өөрийн видео контентын сантай болох
- Багш live-аар хичээл орох нэгдсэн платформтай болох нь хөндлөнгийн хяналт тавихад хялбараас гадна мэдээллийн аюулгүй байдлыг хамгаална.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний арга зүй
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ
- Тестийн сан
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн дүнгийн болон голч дүнгийн мэдээ
- Суралцагчийн өргөдөл, гомдол
- Сургалтын журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дадлагын болон төгсөлтийн шалгалтыг тодорхой бүтээлээр хамгаалдаг.
- Тухайн суралцагчийн үнэлгээнд мэргэжлийн багш нарын оролцоог хангадаг тогтсон уламжлалтай.
- Хичээл бүрээр үнэлгээний арга зүйг тодорхойлон гаргасан байна.

Анхаарах асуудал:

- Ерөнхий суурийн хичээлүүд болон онолын хичээлүүдийн бие даалт, даалгавруудын үнэлгээний рубрик тодорхойгүй байна.
- Тэнхим хичээл бүрээр хийсэн дүнгийн шинжилгээ, дүнгийн ахиц, дэвшилд улирал бүрээр хийсэн судалгаа шинжилгээ дутмаг байна.

Зөвлөмж:

- Оюутнуудын голч дүн тааруухан байгааг анхаарч, дүнгийн шинжилгээг улирал бүрээр хийж, ахиц, дэвшлээ тодорхойлж хэвших
- Онолын хичээлүүдийн бие даалт болон бусад даалгавруудын үнэлгээний нарийвчилсан рубрикуудыг боловсруулан хэрэглээнд оруулах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги, танхимууд:
ТУС нь СУИС-ийн хичээлийн 1,2 – р байранд үйл ажиллагаа явуулдаг. СУИС– ийн хичээлийн 1-р байр урлагийн сургуулийн стандартаар баригдаагүй, хэм хэмжээг хангаагүй байна.
- Номын сан, лабораториуд
- Жүжиглэх урлагийн танхимууд
- Оюутан театр
- Багш нарын өрөө, тэнхимүүд
- Бүжгийн заал болон спорт заал
- Урсгал засвар, тоног төхөөрөмжид зориулсан зардал
- Оюутны байр
СУИС – ийн оюутны дотуур байр нь 230 оюутан хүлээн авах хүчин чадалтай.
- Дадлагын баазын талаарх мэдээлэл:
Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт байрлах “Харзтай” хээрийн дадлагын баазад оюутнууд дадлага хийх, уран бүтээлээ хийх боломжийг бүрдүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жүжиглэх урлагийн семинарын ангиудыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан засвар хийж, тохижуулсан

- Оюутан театрыг тохижуулж, суралцагчид бодит ур чадвараа сайжруулах боломжийг олгосон
- Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт өөрийн дадлагын баазтай болсон.
- 2016-2017 оны хичээлийн жилд СУИС-ийн хичээлийн 2-р байранд өргөтгөл хийж, бүжгийн урлагийн сургууль хичээллэх болсоноор ТУС-ийн жүжиглэх урлагийн хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнууд бүжгийн болон хөдөлгөөний хичээлийг 186 метр.кв талбайтай бүжгийн зааланд хичээллэх болсон.

Анхаарах асуудал:

- Оюутан театрын хүртээмж муу байдгийг төгсөгчид болон оюутнууд хэлж байсан. Анги, танхим, өрөө тасалгааны хүрэлцээ багатайгаас амралтын өдөр болон оройн цагаар хичээллэх шаардлагатай болдог.
- Хичээлийн I байр нь 1954 онд баригдсан, мэргэжлийн хяналтын байгууллагын актаар нурах аюултай гэж дүгнэгдсэн.
- Дижитал ур чадварыг оюутнуудад олгох медиа студийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Шаардлага:

- Яам болон олон улсын байгууллагын орчин, технологийн нөхцлөө сайжруулах төсөлд хамрагдах, урлагийн сургуулийн зориулалттай хичээлийн байртай болох, оюутны бие даан ажиллах орчныг бүрдүүлэх.
- Оюутан театрын хүртээмжийг нэмэгдүүлэх

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа
- E – контент түвшинд боловсруулсан сургалтын материал
- Цахим сургалтын платформ
- Удирдлагын мэдээллийн Uniculture систем
- КОХА номын сангийн систем
- Мини театрын тоног төхөөрөмж, жижиг хэрэгслүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Удирдлагын мэдээллийн Uniculture системийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн.
- Өөрийн гэсэн цахим сургалтын платформыг ашиглан хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- ОХУ-ын судалгааны сангаас оюутнууд судалгааны материал, эх сурвалжуудыг авч ашиглах боломж нээгдсэн.

- Оюутнуудын бүтээлээ туурвих боломжийг бүрдүүлж, их8 бага театр, бүжгийн заал, урлан зэргийг сургалтад ашиглаж, бүтээлээ туурвих боломжийг бүрдүүлсэн.
- Театрын урлагийн сургууль нь “Яруу зохист” сургалтын студи байгуулж “Кинонд дуу оруулах”, “Эфирт микрофонтой ажиллах арга зүй”, “Хөтлөгчийн ур чадвар”, “Тайзны яриа” зэрэг хичээлүүдийг зохион байгуулж байна.
- Дуулах ур чадварын болон бүжгийн хичээлд шаардлагатай хөгжим хэрэгслийн сайжруулалтыг тогтмол нэмэгдүүлж, нүүр хувиргалтын хичээлийг театрын зориулалттай будаг, хэрэгслээр сургуулиас хангаж өгч сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

Анхаарах асуудал:

- Цахим сургалтын видео хэрэглэгдэхүүнүүдээр оюутнуудыг хангах
- Оюутнуудын болон багш нарын бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлэх тал дээр анхаарах
- Монгол хэл дээр хэвлэгдсэн хөтөлбөрийн үндсэн сурах бичиг байхгүй.
- Технологийн нөхцлөө сайжруулж, өндөр хурдны утасгүй интернэтийн сүлжээг бий болгон дотоод сүлжээг оновчтой зохион байгуулснаар орчин үеийн технологи, программ хангамж ашиглах, мэргэжлийн тоног төхөөрөмжөөр хангах

Зөвлөмж:

- Багш, оюутнуудын бүтээл, ялангуяа төгсөлтийн жүжгүүд, тайлангийн жүжгүүдийг цахим хэлбэрт шилжүүлэх
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүнд видео контентуудыг нэгдсэн стандартаар бэлтгэх тал дээр анхаарч ажиллах
- Студи, театр, лабораторид ажиллах цагийг нэмэгдүүлж уран бүтээлийг чанаржуулах, тоог нэмэгдүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэх үр ашигтай зарцуулах

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт
- Оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа
- Номын сангийн журам
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ТУС-ын номын сан нь 2019 оны 9-р сарын байдлаар 18,207,760 төгрөгийн үнэ бүхий нийт 345 нэр төрлийн 1179 номын фондтой байна. Үүнээс жүжиглэх урлаг хөтөлбөрт

хамаарагдах ном 175 нэр төрлийн 535 ширхэг ном байна. Мөн эдгээр хөтөлбөртэй холбоотой орос хэл дээрх 84 ширхэг ном бүртгэгджээ.

- Сургуулийн хэмжээнд бүх номын сангууд КОХА програмыг авч хэрэглэж байна. СУИС-ийн Төв номын сан 200 - аад цахим ном, 2,000-аад нот, 400 гаран магистрын ажлын цахим сан хөмрөгтэй.
- КОХА програм нь нийт есөн модультайгаас 6 модулийг ашиглан үйлчилгээ явуулж байна. 2014 - 2018 оны гурван нэрийн өдөр тутмын цахим номын архивтай болсон. Цахим сан хөмрөгийг бүрдүүлэх зорилгоор нот, эрдэм шинжилгээний бүтээлийг дижитал хэлбэрт оруулах ажил өрнүүлсэн бөгөөд одоогийн байдлаар 2,000-аад нот, 600 гаруй магистрын бичвэрийн ажлыг дижитал хэлбэрт оруулаад байна.
- 2002 оноос “Lib4U” PC 1.0 програмыг авч хэрэглэснээр дижитал номын сангийн эхлэл тавигдсан. КОХА програмыг авснаар нэгдсэн нэг програм хангамжаар, нэгдсэн каталогоор үйл ажиллагаа явуулах болсон.
- Номын фондод зарцуулсан төсөв сүүлийн 3 жилийн байдлаар өссөн үзүүлэлттэй байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн хичээлүүд дээр ашиглагдах зарим номнууд орос хэл дээр байгааг анхаарч, англи ном, сурах бичиг эсвэл монгол хэл дээр ашиглах боломжийг оюутнуудад олгоход анхаарах.
- Номын сангийн 1 оюутанд ноогдох талбайн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг судлах.

Зөвлөмж:

- Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлэх үүднээс номын санчийг мэргэшүүлэх нь зүйтэй юм.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл
- Хөтөлбөртэй холбоотой ирсэн санал, гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Тайлан, төлөвлөгөөний хэрэгжилт
- Тэнхимийн урт, богино хугацааны төлөвлөгөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг байнга тодорхойлон ажиллаж байна.
- Хөтөлбөрийн хороо, салбар хороодууд чиглэлийн дагуу ажиллаж, хөтөлбөр боловсруулах нэгдсэн удирдамж чиглүүлгээр ханган ажиллаж байна.
- Тэнхимийн хувьд сүүлийн жилд төлөвлөгөөнд тусгасан ажлууд 100 хувь биелсэн байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын хэлний мэдлэгийг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, инновацийн төсөлт ажлуудад багш нарын оролцоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагчдын солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм, журам
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт, материал
- Төгсөгчдийг давтан сургалтанд хамруулсан талаарх материалууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2016 – 2018 онд олон улсын түвшинд томоохон 3 төслийг хэрэгжүүлж, бүтээлүүд туурвисан.
- 2015 оноос хойш ОХУ, Сингапур, ХБНГУ, Япон зэрэг орнуудаас 9 профессор багшийг урин, сургалтуудыг зохион байгуулсан.
- Төгсөгчдөд зориулсан сургалтуудыг зохион байгуулж хэвшсэн .

Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбоог албан ёсоор байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн нийт орлогыг үндсэн үйл ажиллагааны орлого / сургалтын төлбөр /, төсөл хөтөлбөрийн орлого /гадаад дотоодын төсөл, уран бүтээлийн орлого/, бусад

орлого /богино хугацааны сургалт, ном гарын авлага борлуулах, хүүний орлого/ зэргээс бүрдүүлдэг. Сургуулийн нийт орлогын 80-90 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого эзэлж байна. Үүнээс жүжиглэх урлаг хөтөлбөрийн орлого нь үндсэн үйл ажиллагааны 75-85 хувийг бүрдүүлж байна.

- Жил бүрийн санхүүгийн тайланд шинжилгээ хийж нэг оюутанд ногдох зардал болон орлогыг тооцдог бөгөөд үндсэн үйл ажиллагааны орлогын 50-60 хувийг сургалттай холбоотой зардалд, 40 - 50 хувийг бусад зардалд зарцуулж байна.
- Оюутны курсын болон дипломын жүжгийн санхүүжилтэнд жил бүр 10,0-15,0 сая төгрөгийг зарцуулж хувцас хэрэглэл, тайз, жижиг хэрэгслийг баяжуулж байдаг.
- Хөтөлбөрийн орлогыг нэмэгдүүлэх, нийт орлогод эзлэх бусад орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 2014-2018 онуудад оюутны бүтээл “Алиса гайхамшигийн оронд”, “Наран ээжийн эрэлд”, “Бэмби”, “Миний хайрыг хүлээ” зэрэг жүжгүүдийг оюутан театр болон гадны байгууллагуудын захиалгаар тоглож орлогоо нэмэгдүүлэн ажилласан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ТУС-ийн орлогын дийлэнх хувийг тухайн хөтөлбөрөөс орох орлого эзэлж байна.
- Оюутны курсын болон дипломын жүжгийн санхүүжилтэнд жил бүр тодорхой санхүүжилт хийж хэвшсэн.
- 1 оюутанд зарцуулах зардлыг нарийвчлан тооцож, сургалтын төлбөрийн кредитийн үнэлгээг тогтоож хэвшсэн.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн төлбөрийн орлогоос бусад орлогыг нэмэгдүүлэх, багш оюутны хамтарсан уран бүтээлийн төсөл хэрэгжүүлэх, зардлыг үр ашигтай төлөвлөх, зарцуулах, багш нарыг олон улсын сургалт, семинарт хамруулах
- Бусад орлогын эх үүсвэргүй

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Маркетингийн сурталчилгааны материалууд
- Хавсарга хөтөлбөрийн мэдээлэл
- Телевизүүд болон сонин хэвлэлд багш нарын өгсөн ярилцлага
- Зарим байгууллагуудтай байгуулсан гэрээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Интернет маркетингийн идэвхижүүлэлтийн иж бүрдлийн элементүүдийг хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахад хэрэглэж эхэлж байна.

- “Жүжиглэх урлаг” хөтөлбөрөөр төгсөгчийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх зорилгоор “Урлаг судлал-жүжигчин”, “Утга зохиол судлал-жүжигчин” хос, Жүжигчин суурьтай хөтөлгөч, нэвтрүүлэгч хавсрага хөтөлбөр тус тус боловсруулж, 2017-2018 оны хичээлийн жилд 25 оюутан элсэж, хавсарга хөтөлбөрөөр 2018-2019 оны хичээлийн жилд 4 оюутан төгссөн байна.
- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөний хүрээнд олон нийтийн телевиз, мэдээллийн хэрэгслээр мэргэжил сурталчилах зорилгоор UBS, NTV, MN25, TV5, TV9 телевизүүдийн танин мэдэхүйн болон соёл урлаг, хөгжөөнт нэвтрүүлгүүдтэй хамтарч ажиллах, Өдрийн сонин, Өнөөдөр сонин, TV zone сэтгүүлд ярилцлага өгөх, оюутны уран бүтээлийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр оргил цагуудад нэвтрүүлж, олны хүртээл болгох, оюутны төслийн уран бүтээлийг бүрэн эхээр нь бичлэг хийж, архивын баримт болгон хадгалах тал дээр анхаарч, гэрээ байгуулж хамтарч ажиллаж байна.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС – ийн веб хуудас, түүний мэдээллийн иж бүрэн байдал
- Элсэлтэд чиглэсэн брошур, мэдээллийн хэвлэмэл материалууд
- Сошиал хуудас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС – ийн ТУС – ийн хэмжээнд веб хуудсанд байнга мэдээллүүд шинэчлэгдэн ордог.
- Шаардлагатай тохиолдолд тэнхимийн багш нар төлөвлөгөөний дагуу хэвлэмэл сонин, сэтгүүлүүд болон телевизийн нэвтрүүлгүүдэд оролцож, тухайн үеийн мэдээллийг хүргэдэг.
- СУИС-ийн ТУС-ийн цахим хаяг: <http://sssa.mnuac.edu.mn/main/426727>. Энэ нь гадны хүмүүст мэдээлэл хүргээд зогсохгүй сургууль хамт олноороо нэг мэдээ мэдээлэлтэй байж, нэг удирдлага зохион байгуулалтанд сургалтын үйл ажиллагаа явагдахад эерэгээр нөлөөлдөг.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Тэнхимийн зүгээс суралцагчид болон тэдний эцэг эх, асран хамгаалагчид тухайн үеийн мэдээллийг цаг алдалгүй авч байх боломжийг бүрдүүлж, өөрийн веб хуудсыг ажиллуулах

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журам
- Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа. Сүүлийн 5 жилийн байдлаар элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо 500 – 550 хооронд хэлбэлзэж байна.
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо. Жилд 3 – 10 гадаад оюутанг элсүүлэн сургаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгчдийн хувьд авъяас, ур чадвар, ЭЕШ – ын онооноос гадна ёс зүйн хэм хэмжээг чандлан мөрддөг, бие бялдар, хэл яриа, ерөнхий мэдлэгийн хүрээг харгалзан үзэж, элсэгчдийг сонгон шалгаруулдаг.
- Элсэгчдэд зориулсан сургалтыг урьдчилан зохион байгуулдаг.
- Ерөнхий шалгалтын онооноос гадна ур чадварын шалгалтыг авдаг. Элсэгчдийн хувьд хөдөлгөөний эвсэл, дуулах ур чадвар, сонсгол, ритм, уран уншлага зэргийг шалгуулахаас гадна өгөгдсөн судалбар дээр ажиллах, оюуны чадамжийг тодорхойлох даалгаваруудыг гүйцэтгэн, ярилцлага өгдөг.
- “Бадмаараг” ахлах сургуультайгаа хамтран ажилладаг

Анхаарах асуудал:

- ӨМӨЗО-оос цөөн тооны оюутан элсэж байгаа боловч, гадаад оюутны тоо сүүлийн жилүүдэд өсөөгүй байна.

Зөвлөмж:

- Гадаад оюутан сонирхсон мэдээллээ шууд авах боломжийг бүрдүүлэх (веб хуудасыг англи хэлний сонголттой болгох г. м.)

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн онцлогоос шалтгаалан ангийн багшийн үүрэг оролцоо маш өндөр
- Оюутнууд багийн ажиллагааны онцлог, давуу чанарыг гүнзгий ухамсарласан
- Сургалтын бодлого зохицуулалтын газрын дэргэд оюутны үйлчилгээ хариуцсан алба, “Оюутны хөгжлийн төв” ажилладаг.
- Оюутанд үзүүлэх үйлчилгээний төлөвлөгөөг жил бүр батлан, жилийн эцэст үр дүнг нь үнэлэн, дараа жилийн төлөвлөгөөнд сайжруулалтыг хийж ажилладаг.
- Оюутанд зөвлөх багшийг томилон ажиллуулдаг бөгөөд оюутан тухайн зөвлөх багшийн тусламжтайгаар өөрийн сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, тулгамдсан асуудлаа шийдүүлэх замаар сургуулийн орчинд дасан зохицоход нь багш нар дэмжлэг үзүүлж хэвшсэн.

Анхаарах асуудал:

- Зөвлөх багш нь оюутны дийлэнх асуудлыг шийдэхэд туслалцаа үзүүлж байгаа нь багш нарын хувьд нэмэлт ачаалал үүсгэх тал байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Сэтгэл зүйн зөвлөлгөө өгөх, хууль, эрх зүйн чиглэлээр мэдлэг олгох тал дээр мэргэжилтнүүдийг татан оролцуулж, хэрэгжүүлж буй ажлуудыг эрчимжүүлэх.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл.
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр суралцагч оюутнууд ЕБС, цэцэрлэгийн хүүхдүүдийн төрөл бүрийн арга хэмжээнд зориулсан концерт, уралдаан тэмжээнийг зохион байгуулахад туслахаар, шүүгчээр оролцож хамтран ажилладаг.
- СУИС-ийн дэргэдэх “Оюутны хөгжлийн төв”-өөс жил бүр хичээлээс гадуур зохион байгуулах үйл ажиллагааны график гарган батлуулж, ажиллаж байна.
- СУИС-аас нийгэмд хандсан сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулж, тус хөтөлбөрөөр суралцагч оюутнууд болон багш нар энэхүү арга хэмжээнд идэвхитэй оролцдог. Үүний заримаас дурдвал: “Соёлын наадам”, “Гудамжны баяр” зэргийг нэрлэж болно.

- 2018-2019 онд нийт 7 арга хэмжээнд давхардсан тоогоор 150 орчим оюутан оролцсон байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон оролцоог үнэлэх

Зөвлөмж:

- Уран бүтээлд оролцож буй суралцагчдын үнэлгээний асуудал, аюулгүй байдлыг хангах асуудлыг нэгдсэн бодлогоор зохицуулах

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын журам
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа. Сүүлийн 5 жилийн шилжилт хөдөлгөөний судалгаанаас үзэхэд, гадны сургуулиас шилжиж ирсэн 5 оюутан байгаа бол, жилийн чөлөө авсан, төгсөлт хойшилсон оюутны тоо жилд дунджаар 17 байна.
- Сургуулиас чөлөөлөгдсөн оюутны тоо сүүлийн 3 жилд өссөн дүнтэй байна. 2016 – 2017 онд 18, 2017 – 2018 онд 31, 2018 – 2019 онд 25 оюутан байгаагийн дийлэнх хувийг ар гэрийн боломжгүй байдлаа шалтгаалан чөлөөлүүлэх хүсэлт эзэлж байна.
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн ур чадварыг харгалзан олон үе шаттай элсэлтийн шалгалтыг давж, элсдэг учир, сургалтын дундаас өөр бусад сургуулиас шилжин орж ирэх тохиолдол цөөн.
- Их сургууль дотроо шилжилт хөдөлгөөн хийх боломжийг санал болгодог.

Анхаарах асуудал:

- Шилжилт хөдөлгөөн хийхэд мэргэжлийн багшийн саналыг цаашид ч анхаарч байх

Зөвлөмж:

- Төлбөрөөс хамаарсан шилжилт хөдөлгөөнийг шийдэх боломжуудыг эрэлхийлэх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн шалгалтын журам. Төгсөлтийн шалгалтыг тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийн агуулгын хүрээнд жүжиглэх, найруулах ур чадварын улсын шалгалт, төгсөлтийн бичвэрийн ажлын хамгаалалт гэсэн үндсэн хоёр төрлөөр явуулдаг.
- Төгсөлтийн баримт бичгийн загвар

- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичгийг англи хэл дээр болгосон

Анхаарах асуудал:

- Төгсөлтийн баримт бичгээр цаашид ижил мэргэжлээр болон үргэлжлүүлэн сурахад гарах асуудлуудыг тодруулах

Зөвлөмж:

- Европын болон гадаадын их дээд сургуулиудын кредитийг хүлээн зөвшөөрөх байдалд шинжилгээ хийж, төгсөгчдөө цаашид үргэлжлүүлэн суралцах тал дээр дэмжлэг үзүүлэх

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн, туршлагатай багш нарын баг хамт олонг бүрдүүлсэн. Тус хөтөлбөрт Монгол улсын ардын жүжигчин 5, Урлагийн гавъяат зүтгэлтэн 4, Төрийн соёрхолт багш 1 ажиллаж байна.
- Багшийг сонгон шалгаруулах бодлого нь СУИС-ийн мастер төлөвлөгөөтэй уялдсан байна.
- Мэргэжлийн чадварлаг багийг бүрдүүлсэнээс гадна 1 багшид ноогдох оюутны тоо харьцангуй цөөн буюу дунджаар 1 багшид 9 оюутан ноогдож байна.

- Нийт багш нарын дунд эрдмийн болон мэргэжлийн өндөр зэрэгтэй багшийн эзлэх хувь 31.1 хувьтай байгаа бол, 16 багш докторантурт суралцаж байна.
- Ассистент багш нарыг ажиллуулж эхэлсэн.

Анхаарах асуудал:

- Цагийн ачаалал хэвийн харагдаж байгаа боловч мэргэжлийн онцлогийг тусгах нэн шаардлагатай.

Зөвлөмж:

- Магистрантур, докторантурт суралцаж байгаа суралцагчдыг багшийн туслахаар ажиллуулах, төгсөх курсын оюутныг “Tutor” болгох зэрэг аргачлалуудыг нэвтрүүлэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт
- Төлөвлөгөө, тайлан
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа.
- Багшийн ажлын дэвтэр
- СУИС – ийн хөгжлийн мастер төлөвлөгөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалт, семинаруудын ач холбогдолыг мэдэж үнэлсэн.
- Багшийн ажлын дэвтэр нь “Багшийн өөрийн хөгжлийн хөтөлбөр” хэсэгтэй бөгөөд багш өөрийн үйл ажиллагаа, хөгжлийн төлөвлөгөөгөө энэ загварын дагуу төлөвлөдөг.
- Тодорхой чиглэлүүдээр залгамжлалыг бий болгох бодлогыг хэрэгжүүлэн, ардын жүжигчин Ж.Лхамхүү, төрийн соёрхолт найруулагч Н.Наранбаатар нар залуу багш нарыг дагалдуулан ажиллаж байна.
- “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд 2016 оноос хойш нийт 13 удаагийн томоохон сургалт, семинаруудыг багш нарт зориулан зохион байгуулсан бөгөөд үүнээс 4 удаагийн сургалт нь гадаадын судалгааны байгууллага, их дээд сургуулиудаас авсан сургалт байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн онцлогоос хамааран багш нар гадны оронд мэргэжил дээшлүүлэх тал дээр илүү анхаарах
- Эдгээрт сургуулиас зарцуулах санхүүгийн нөхцөлийг уян хатан болгох

Зөвлөмж:

- Гадны тэтгэлэгт хөтөлбөр, багш солилцооны гэрээтэй ажиллаж буй сургуулиудаа дахин сайтар судлах

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- СУИС – ийн Эрдмийн зөвлөлийн “Профессорын багийн нэр, орон тоо” – г баталсан тогтоол
- СУИС – ийн эрдэм шинжилгээ, сургалт, уран бүтээл, соёлын үйлдвэрлэлийн төв байгуулж ажиллах журам
- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгаа
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо
- Зарцуулсан төсөв, тайлан
- Сүүлийн 5 жилд гадны байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээ, инновацийн 10 төслийг хэрэгжүүлсэн.
- Нийт зардалд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлын эзлэх хувь 1.4 хувиас хэтрэхгүй байгаа бөгөөд төлөвлөсөн үзүүлэлтэд жил бүр хүрээгүй гүйцэтгэлтэй байна.
- Сүүлийн жилүүдэд тус тэнхимийн багш нараас 7 багшийн бүтээл эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлэгдсэн бол, 3 орчуулгын бүтээл, 3 шүүмжийн эмхэтгэл, 33 мэргэжлийн ном сурах бичиг, гарын авлагыг хэвлүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хандах хандлага сайжирсан
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих эрх зүйн орчин сайжирсан

Анхаарах асуудал:

- Багш нар судалгааны ажлаа сургуулийн эсвэл үндэсний хүрээнд хэвлүүлж байгаа боловч, гадаадад хэвлүүлсэн бүтээл ховор байна.
- Багш нарыг гадаадад бүтээлээ хэвлүүлсэн нөхцөлд урамшуулах асуудал дүрэм, журамд туссан боловч, хэвлүүлэх хүртэлх хугацаанд үзүүлэх дэмжлэг тодорхойгүй байна.

Зөвлөмж:

- Уран бүтээлийн ажлуудыг эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл болгох боломж, аргачлалыг хайх
- Багш нарыг гадаадад бүтээлээ хэвлүүлэх, гадны эрдэмтэдтэй хамтарсан судалгаа хийх тал дээр дэмжлэг үзүүлэх

Шаардлага:

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын сэдвийг шинэчлэх, цар хүрээг тэлэх

- Багш нарын бүтээлийг олон улсын хөндлөнгийн хянан магадлагаа бүхий сэтгүүлүүдэд хэвлүүлэх, гадаад хэлэнд хөрвүүлэхэд анхаарах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөндлөнгийн үнэлгээний дүн
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан мэдээ
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш бүр мэргэжлийн онцлогийн дагуу өөрийн хавтасыг бүрдүүлсэн

Анхаарах асуудал:

- Хичээлийн онцлогоос шалтгаалан материалын бүрдүүлэлтийн ойлгомжтой байдал дээр анхаарах
- Цахим ашиглалтыг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Өөрийн үнэлгээний тайлан болон бодит ажилын цагийн хоорондох зөрүүг багш болон тэнхимийн хүрээнд нарийвчлан судлаж үнэлгээний онцлогийг тогтоох

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц
- Хөтөлбөрийн хорооны журам
- Хөтөлбөрийн ерөнхий болон дэд хорооны бүтэц
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын баримт бичгүүд
- Багш ажилчдад зориулсан сургалтын материалууд
- Төгсөгчийн мөшгөх судалгааны тайлан

- Оюутнуудын болон төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан
- Дотоод чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр 2016 - 2019

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017 онд чанарын дотоод баталгаажуулалтын 1566 шалгуур үзүүлэлтийг PDCA аргачлалын дагуу боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.
- 2013 – 2014 онд сургалтын хөтөлбөрийн замын зураглалыг гаргаж, хөтөлбөрт өөрчлөлт сайжруулалт хийх алхмуудыг тодорхой болгосон.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн чанарын батлагаажуулалтын шалгуур үзүүлэлтүүд, тэрхүү үзүүлэлтүүд ямар түвшинд байвал, зайлшгүй өөрчлөлт хийх шаардлагатай эсэх нь тодорхойгүй байна.
- Судалгааны үр дүнгүүдийн нэгдсэн сан, динамик үзүүлэлтүүдэд хийгдсэн шинжилгээ дутмаг байна.
- Оюутнуудын голч дүн, хичээлүүдийн дүнгийн өсөлт, бууралтад хийсэн шинжилгээ дутмаг байна.

Шаардлага:

- Тэнхим мэргэжлийн хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрийн боловсруулалтаа хэрхэн үнэлэхээ тодорхой болгох
- Хичээлүүдийн болон голч дүнгийн өсөлт бууралтад дүн шинжилгээ хийж, хэвших
- Судалгааны нэгдсэн санг бүрдүүлэх, uniculture системийн тусламжтайгаар шаардлагатай нэгдсэн үнэлгээнүүдийг нэгжүүдэд тухай бүрт нь мэдээлж, тэрхүү үр дүнд тулгуурлан авч хэрэгжүүлсэн арга хэмжээг оюутнуудад ил тод мэдээлж хэвших

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа
- Төгсөгчдийн мөшгөх судалгаа
- Ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгааны тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг хийж хэвшсэн байна.

- Төгсөгчдийн мөшгөх судалгааг тодорхой давтамжтайгаар хийж хэвшсэн бөгөөд ажил олгогчийн шаардаж буй ур чадвар, төгсөгчийн ур чадварын зөрүүг тодорхойлж шинжилсэн нь давуу талтай байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн судалгаанд хамрагдалтын хувь зарим жилүүдэд бага байна.

Зөвлөмж:

- Төгсөгчид соёл урлагийн, боловсролын байгууллагад ажиллахын зэрэгцээ чөлөөт уран бүтээлчээр ажилладаг тул, илүү хөрвөх чадвар олгох боломжийг эрэлхийлэх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- 2012 онд шинжээчийн багаас өгсөн зөвлөмж, дүгнэлт
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ
- Дотоод гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй суралцагчдын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2 дахь удаагаа магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж, өөрийн үнэлгээ хийсэн нь том давуу тал болно.
- Европын Урлагийн сургуулиудын холбооны чанарын баталгаажуулалтын сургагч багш нартай хамтран ажиллах эхлэл тавигдсан.
- Чанарын баталгаажуулалтын чиглэлээр гаднаас зөвлөх багш нарыг урьж, 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.
- Дараагийн удаа олон улсад чанарын баталгаажуулалт хийлгэхээр төлөвлөгөөнд тусгасан байна.

Зөвлөмж:

- Олон улсад магадлан итгэмжлүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлэх

ДҮГНЭЛТ

№	Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	1.1 1.2	1.3		Мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж, шинээр боловсруулсан хөтөлбөрийг баталгаажуулаагүй

					байгаа бөгөөд цогц чадамжийн хандлага хэсэгт зарим чадварууд орсон, хичээлийн суралцахуйн үр дүнгүүд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй цөөн газар зөрсөн байгааг засварлах шаардлагатай.
2	Сургалтын үйл ажиллагаа	2.1 2.2 2.3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3.2 3.3	3.1		Сургуулийн барилга хуучирч, стандартын шаардлага хангахгүй болсоныг анхаарч, барилгын асуудалд удирдлага онцгой анхаарал тавьж ажиллах шаардлагатай.
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4.1 4.2 4.3 4.4 4.5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5.1 5.2 5.3 5.4			
6	Багшийн үйл ажиллагаа	6.1 6.2 6.4	6.3		Эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын сэдвийг шинэчлэх, цар хүрээг тэлэх
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	7.2 7.3	7.1		Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, хэрэглээнд оруулах, дүнгийн шинжилгээ хийж хэвших. Гол нь судалгааны үр дүнгийн динамик үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийх нь чухал.
	Дүгнэлт	Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг СУИС-ийн Театрын урлагийн сургуулийн “Жүжиглэх урлаг” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул

“Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/ С.Эрдэнэтуул/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ А.Баярмэнд/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Г.Батхуяг/

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. 2020 онд төгсөгчийн цогц чадамжийг тодорхойлон, хөтөлбөрийн матрицийг боловсруулж сайжруулалт хийсэн мэргэжлийн хөтөлбөрөө баталгаажуулан хэрэглээнд оруулах. Цогц чадамжид тусгасан мэдлэг, чадварын давхцсан утга санааг засварлах, хичээлийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг хөтөлбөрийн үр дүнтэй илүү нягт уялдуулах.
2. Сургуулийн хичээллэх байрыг урлагийн сургуулийн стандартад нийцсэн зай талбайтай болгон тхоижуулах, урлагийн заалуудын хүртээмжийг нэмэгдүүлэх.
3. Хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчдын тавьж буй шаардлагад гарч буй өөрчлөлтийг харгалзан, төгсөгчдийн технологийн чадвар, камертай ажиллах чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч, одоо төлөвлөсөн байгаа ажлуудаа үргэлжлүүлэх.
4. Орон нутгийн урлагийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулах
5. Багш нарын судалгаа эрдэм шинжилгээний ажлыг дэмжих тал дээр анхаарч, судалгааны ажлын чансааг дээшлүүлж, олон улсад бүтээлээ хэвлүүлэх, хамтарсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх тал дээр сургуулиас тодорхой бодлого гарган ажиллах.
6. Суралцагчдын голч дүн доогуур байгаад анхаарч, ерөнхий суурийн хичээлийн агуулгыг мэргэжлийн агуулгатай холбох, суралцагчдын дүнгийн шинжилгээг хийж, оролцогч талуудын судалгааны үр дүнгийн динамик байдалд шинжилгээ хийж хэвших.
7. Мэргэжлийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн суурь хэмжигдэхүүнүүдийг тодорхой болгох, ямар нөхцөлд хөтөлбөрт сайжруулалт хийх шаардлагатайг тодорхойлох.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

Багш нарын төлөөлөл

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас	Гарын үсэг
1	С.Болормаа	Багш	НЖУТ/жүжиглэх урлаг хөтөлбөр	99146130	
2	Ж.Лхамхүү	Зөвлөх багш	НЖУТ/жүжиглэх урлаг хөтөлбөр	99776802	
3	Ж.Оюундарь	Багш	НЖУТ/жүжиглэх урлаг хөтөлбөр	99168989	
4	Г.Амгаланбаатар	Багш	НЖУТ/жүжиглэх урлаг	88880440	
5	Б.Отгонбат	Ахлах багш	НЖУТ/жүжиглэх урлаг	88110707	
6	Я.Билгүүнсар	Туслах багш	НЖУТ/жүжиглэх урлаг	80028002	
6	Б.Даваа	Ахлах багш	ЯУТ/ тайзны яриа	99037662	
7	С.Гантулга	Багш	ЯУТ/ дуулах урлаг	99002821	
8	Б.Долгоржав	Ахлах багш	ЯУТ/ хөгжмийн боловсрол	99122086	
9	П.Батхуяг	Тэргүүлэх профессор	ЯУТ/ урлаг судлал	99162543	
10	Б.Энхгэрэл	Багш	ЯУТ/ кинонд дуу оруулах урлаг	99103392	
11	Р.Нацагдоо	Ахлах багш	ЯУТ/ тайзны яриа	80204260	

Оюутны төлөөлөл

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас	Гарын үсэг
1	Г.Отгонбат	ХТЖ	Оюутны зөвлөл	88629962	
2	А.Азжаргал	ХТЖ	Хот	95154889	
3	Б.Анударь	ЖУ-2Б	Хот	94352919	
4	Б.Чингүнжав	ЖУ-2Б	Хот	90668699	
5	Энхжин	ЖУ- 3а	хот	99399448	
6	Ц.Нямдорж	ЖУ- 3а	Сэлэнгэ аймаг	95816180	
7	Б.Биндэрьяа	ЖУ- 4а	Хот	89192191	
8	Т.Алтангэрэл	ЖУ- 4а	Хот	94446688	

9	А.Гэрэлмаа	ЖУ- 4в	Орон нутаг- Увс аймаг	98188992	
10	Т.Лхавгажаргал	ЖУ- 4в	Өвөрхангай	94666169	
11	Г.Баасанхүү	ЖУ- 4Б	Хот	91818740	

Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1	Х.Тэмүүжин	“Эмоци” продакшины захирал	88095689 88888656	
2	Н.Наранбаатар	УДЭТ-ийн ерөнхий найруулагч	99115539	
3	Ц.Энхтуяа	UBS телевизийн программын албаны дарга	99599813 99041764	
4	Ц.Цанжидмолон	Өвөрхангай аймгийн Хөгжимт жүжгийн театрын уран сайхны удирдагч	99974433	
5	С.Баттулга	“Хэрүб энтертайнмент” захирал	96531393	
6	Г.Ундармаа	“U film” захирал	88888161	
7	Д.Доржсүрэн	Дундговь аймгийн Төв Халхын дуулалт жүжгийн театрын дарга	99599813	
8	Д. Саранхүү .	“Цоглог” студийн захирал	96995544	
9	П.Эрдэнэзаан	“Маск” продакшны захирал	99113478	
10	Э.Идэрболд	Дорноговь аймгийн “Саран хөхөө” театрын дарга	88093717	

Төгсөгчдийн төлөөлөл

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1	Г.Ганбат	2016	УДЭТ-жүжигчин	99909019	
2	Г.Мягмарцэцэг	2016	УДЭТ-жүжигчин	99909019	
3	И.Төмөрхуяг	2015	Мааз продакшн жүжигчин	90180404	
4	Р.Сүхболд	2015	Мааз продакшн жүжигчин	99008120	

5	Б.Золзаяа	2016	УДЭТ- жүжигчин	99231900	
6	О.Майдарравжаа	2018	УДЭТ- жүжигчин	99294912	
7	Б.Болдхүү	2017	Шанхайн театрын академид оюутан	91383898	
8	Б.Батмаа	2017	Кино жүжигчин	91111103	
9	С.Идэрмаа	2018	U-Film жүжигчин	88771030	
10	Б.Шинэбаяр	2013	УДЭТ- жүжигчин	90100009	
11	Н.Бямбасүрэн	2014	СУИС-ТУС багш	99946343	

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ
ТЕАТРЫН УРЛАГИЙН СУРГУУЛЬ

15140 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 26, Утас: 32-41-37, Факс: +976-31-56-05

2021.04.01 № 01/23
танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

Тус сургуулийн “Жүжиглэх урлаг” хөтөлбөрийг
магадлан итгэмжлэх шинжээчийн баг 2021 оны 03-р
сарын 1-2-ны өдрүүдэд сургууль дээр ажилласан.

Дээрх ажлын хүрээнд гаргасан шинжээчийн
багийн тайланг 2021 оны 03-р сарын 30-ны өдөр хүлээн
авч, тус сургуулийн захиргаа, хамт олон танилцсан
бөгөөд тайланг хүлээн зөвшөөрч байгааг мэдэгдэж
байна.

ЗАХИРАЛ



Д.ДАВААСҮРЭН